# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН АКТ

2015 оны 12 сарын 10–ны өдөр Дугаар ...42/2015. Улаанбаатар хот

## НЭГ

1.1 Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал

**Дундговь аймгийн Сайнцагаан сумын төвийн долоо дугаар баг Эрүүл мэндийн яамны захиалгатай " Эрүүл мэндийг дэмжих төв"-ийн барилга**

1.2 Захиалагч аж ахуй нэгж, байгууллага (Зөвлөх үйлчилгээ эрхлэгч )

**Эрүүл мэндийн яам**

1.3 Ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага

**Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар**

1.4 Ерөнхий болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага

**" Ганцаг" ХХК**

1.5 Зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгж , байгууллага

**" Өлзий-Иш" ХХК**

1.6 Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 151 дүгээр тогтоол шийдвэрээр зохион байгуулсан **18** хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс нь уг барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай захиалагч байгууллагын 2015 оны 11 сарын 30 –ны өдрийн 1/72 дугаар мэдэгдлийн дагуу 2015 оны 11 сарын 30-ны өдрөөс 30-ны өдөрт багтаан шинээр барьсан, өргөтгөл, шинэтгэл, их засварын ажлын чанар холбогдох акт, баримтуудтай танилцаад газар дээр нь шалган үзэв.

1.7 Энэхүү барилга байгууламжийг **ӨИ-04-12** дугаартай зураг төслөөр 2012 оны 10 сараас барьж эхэлсэн бөгөөд 2015 оны 11 сарын 25-ны өдөр барьж дуусгасан байна.

## ХОЁР

2.1 Энэхүү **<u>Дундговь аймгийн Сайнцагаан сумын 7-р баг Эрүүл Мэндийн Газрын захиалгатай " Эрүүл Мэндийг Дэмжих Төв"-ийн оффисийн барилга</u>** барилга байгууламж, холбогдох акт, баримтуудыг шалгаад ашиглалтад оруулах тухай комиссоос ШИЙДВЭРЛЭСЭН нь:

03



***Байнгын ашиглалтанд оруулахаар шийдвэрлэв.***

2.2 Энэхүү барилга байгууламж нь зураг төслийн дагуу бүрэн хийгдэж

***Оффиссийн барилгын***

зориулалтаар ашиглахад_ боломжтой гэж үзээд захиалагч (ашиглагч) байгууллага болох Эрүүл мэндийн газрын мэдэлд 2015 оны 11 сарын 30-ны өдрөөс ашиглалтад (үйлдвэрлэл, үйлчилгээ, оршин суух зэрэг) оруулахыг зөвшөөрөв.

2.3 Комиссоос даалгах нь:

Гүйцэтгэгч байгууллагад:

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт, холбогдох баримтуудын эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч байгууллагад .... хоногийн дотор багтаан шилжүүлэх.

Захиалагч (ашиглагч) байгууллагад:

А) Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн дагуу барилга байгууламжийн хувийн хэрэгт баяжилт хийж байх.

Б ) Барилга ашиглалтын дүрмийн дагуу барилгыг хэвийн ашиглаж, засвар арчлалтыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.

2.4 Комиссын акт .... хуудас, хуралдааны тэмдэглэл .... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт .... хуудас материал, барилга байгууламжийн бичиг, баримтын жагсаалтыг хавсаргав.

**Дундговь аймгийн Сайнцагаан сумын 7-р баг Эрүүл Мэндийн Газрын захиалгатай " Эрүүл Мэндийг Дэмжих Төв"-ийн оффисийн барилга**

КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:

Комиссын дарга:Дундговь аймгийн Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын дарга /Э.Чагнаадорж/

Нарийн бичгийн дарга: " Ганцаг" ХХК-ны Инженер / Ш.Булганаа/

Барилгын хөгжлийн төв, Барилга захиалагчийн хэлтэс ахлах инженер /С.Жамбалнаваг/

МОНГОЛ УЛС
Сүхээгийн ЖАМБАЛНАВАГ
МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР
10-1052

Барилгын хөгжлийн төв, Барилга захиалагчийн хэлтэс хяналтын инженер /Э.Болор/

Барилгын хөгжлийн төв, Барилга захиалагчийн хэлтэс хяналтын инженер /Д.Бат-Эрдэнэ/

Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын газрын мэргэжилтэн / Н.Эрдэнэбат/

Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын

газрын мэргэжилтэн /Л.Бадамболд/

Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын
газрын мэргэжилтэн / Т.Эрдэнэбаяр/

Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын
газрын мэргэжилтэн / Э.Энхмэнд/

Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах
улсын байцаагч /Э.Мөнхбаатар/

Аймгийн Засаг Даргын Тамгийн газрын
Архивын тасгийн дарга /П.Алтанчимэг/

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга / Ц.Энхсайхан/

Аймгийн Засаг даргын тамгийн газрын
Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн / О.Мөнхзул/

Дундговь аймгийн Цахилгаан түгээх
сүлжээ салбарын ерөнхий инженер / С.Энхбат/

"Мэдээлэл холбоо сүлжээ" ХХК-ний
ерөнхий инженер / Л.Баасансүрэн/

" Ган-Илч" ХХК-ний инженер / Б.Зоригт-Эрдэнэ/

" Дундговь-Ус" орон нутгийн өмчит
үйлдвэрийн газрын дарга / Б. Отгонтөгс/

Орон нутгийн өмчийн албаны дарга / П.Очирбат/

Зураг төсөл зохиогч байгууллага:
" Өлзий-Иш" ХХК-ний захирал / А.Ичинхорлоо/

Ерөнхий гүйцэтгэгч:
" Ганцаг" ХХК-ний захирал / Л.Нэргүй/

05



# ДУНДГОВЬ АЙМАГ 7-Р БАГ, " ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨВ"-ИЙН БАРИЛГЫГ БАЙНГЫН АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015.11.30

Дундговь аймаг

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 7-р баг, " Эрүүл мэндийг дэмжих төв "-ийн барилгыг байнгын ашиглалтанд оруулах комиссын хурал 2015 оны 11-р сарын 30-ны өдрийн 15 цаг 30 минутаас тус төвийн барилгад болов.

Комиссын бүрэлдэхүүн

1. Э.Чагнаадорж – ГХБХБГ-ын дарга
2. Ш.Булганаа – Комиссын нарийн бичгийн дарга
3. Н.Эрдэнэбат - ГХБХБГ-ын мэргэжилтэн
4. С.Жамбалнаваг – Барилгын хөгжлийн төв, барилга захиалагчийн хэлтэс хяналтын инженер
5. Э.Болор – БХТ, БЗХ-ийн хяналтын инженер
6. Д.Бат-Эрдэнэ- БХТ, БЗХ-ийн хяналтын инженер
7. Л.Бадамболд - ГХБХБГ-ын мэргэжилтэн
8. Т.Эрдэнэбаяр - ГХБХБГ-ын мэргэжилтэн
9. Э.Энхмэнд - ГХБХБГ-ын мэргэжилтэн
10. Ц.Энхсайхан- Эрүүл мэндийн газрын дарга
11. О.Мөнхзул – Аймгийн ЗДТГазрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
12. Л.Нэргүй – " Ганцаг" ХХК-ний захирал
13. С.Энхбат – Дундговь аймгийн ЦТС салбарын ерөнхий инженер
14. Л.Баасансүрэн- " Мэдээлэл Холбоо сүлжээ" ХК-ний ерөнхий инженер
15. Б.Зоригт-Эрдэнэ- " Ган-Илч" ХХК-ний инженер
16. П.Очирбат- Орон нутгийн өмчийн албаны дарга

Хэлэлцсэн нь: Захиалагч байгууллага Эрүүл мэндийн газрын ГХБХБГазарт гаргасан 2015 оны 11 сарын 30- ний өдрийн ...........тоот комисс ажиллуулах тухай хүсэлтийн дагуу ГХБХБ-ийн .......... тоот мэдэгдлээр барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулах комисс ажиллаж байна.

Комиссын дарга ирц бүрдсэнийг онцолж хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулснаар барилгын үзлэг, шалгалт эхлэв.

Барилга байгууламжийн талаар:

Дундговь аймгийн Засаг даргын 2011 оны 06 сарын 21-ны өдрийн А/330 дугаар захирамжаар эзэмшиж буй **оффисын барилга** зориулалттай 0,9 га газарт ЭМЯамны захиалгаар " **Өлзий- Иш**" ХХК-ийн боловсруулсан **ӨИ-04-12** шифртэй зураг төслийн дагуу барилгын ерөнхий гүйцэтгэгч " **Ганцаг**" ХХК нь зоорьтой, 2 давхар цутгамал,

өрөгт бүтээцтэй оффиссын барилгын, барилга угсралтын ажлыг 2012 оны 10 сараас 2015 оны 11 сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэсэн байна.

Барилгын хэмжээ хийцийн талаар:

Тус барилга нь тэнхлэгээрээ **30,8м*14,4м** хэмжээ бүхий **цутгамал зоорьтой, өрөгт** бүтээцтэй **хоёр** давхар байна.

Эзлэхүүн **4329,0 м3**

Барилгын ашигтай талбай **1096,5**

Барилгын нийт төсөвт өртөг

Гишүүд барилгын зураг төсөл, баримт бичиг , барилга угсралтын ажилтай газар дээр нь танилцаад дараах саналуудыг өгөв.

С.Жамбалнаваг: Барилгын ажлыг явж үзлээ. Подвалийн бохирыг өөрчилсөн байна.Барилга угсралт, засал чимэглэлийн ажлын БНбД, стандарт зураг төслийн дагуу чанартай хийж гүйцэтгэсэн байна.

- Гадна инженерийн шугам сүлжээнүүдийн гүйцэтгэлийн зураг гаргаж баримт хавсаргаж архивт өгөх
- Дээвэрт гарах люкэнд бороо цас орохоос сэргийлж хамгаалалт хаалт хийж өгөх
- Байнгын ашиглалтад хүлээн авах комиссийн бүрэлдэхүүнд ЭМСЯ-с гишүүн томилуулж нөхөж өгөх
- Хавар дулаан улиралд барилгын баруун талд подвальд ус орохоос сэргийлж боломжоороо суваг шуудуу далан хийж өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах

Л.Нэргүй: Манай компани 2012 онд ЭМСЯ-ны захиалгаар эхэлж 750,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

П.Очирбат: Барилга угсралтын ажлыг чанартай сайн гүйцэтгэсэн байна.

- Төсвийн гүйцэтгэлийн задаргааг барилга, дулааны шугам, цэвэр бохир усны шугам гэх мэт задалж материалд хавсаргах

Ашиглалтанд авахад татгалзах зүйлгүй.

Т.Эрдэнэбаяр:

- Гадна шатны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орох шат, зам БНбД-ийн дагуу хийгдээгүй үүнийг стандартын дагуу болгох
- 2 давхараас дээвэрлүү гарах хаалганы битүүмжлэл муу байна. Үүнийг засаж өгөх шаардлагатай.
- Гэрэлтүүлэг зургийн дагуу хийх

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаварын биелүүлсэн тохиолдолд ашиглалтад хүлээн авахад татгалзах зүйлгүй.

Л.Баасансүрэн:

- Дотоод сүлжээний утсыг хаягжуулах

Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах.

Н.Эрдэнэбат:

- Гадна дулаан, бохир усны гүйцэтгэлийн схем хийж материалд хавсаргах
- Гаражын агаар сорох систем угсрах
- Газардуулга эсэргүүцлийг мэргэжлийн байгууллагын эрх бүхий төлөөлөгчөөр хэмжүүлж акт үйлдэх
- Ус,цахилгаан тоолуурын баталгаажуулсан гэрчилгээ, заалтыг тэмдэглэн ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх

Өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлсний дараа ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Б.Зоригт-Эрдэнэ:

- Автомашины гаражын болон зоорийн давхарын хэсгээр явсан магистраль шугмыг бүхэлд нь дулаалах

Үүрэг даалгаврын биелэлтээр барилгыг байнгын ашиглалтанд хүлээн авах саналтай байна.

О.Мөнхзул:

- Гараж болон 2-р давхарын 00-ын өрөөний агааржуулагчийг зургийн дагуу төлөвлөх
- Халаалт ба бохир / гадна/ цахилгаан болон зарим байгуулалтын гүйцэтгэлийн зураг гаргах
- Гадна бохир усны гаргалгааны 2 худаг цэвэрлэх болон дулаалах арга хэмжээ авах
- Ус хаягчид силикон наах
- Дулааны узель дээр өгөлтийн термометр засах

Гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелүүлсэн тохиолдолд барилга байгууламжыг байнгын ашиглалтанд авахад татгалзах зүйлгүй.

С.Энхбат:

- 2016 оны 4 сард барилгын газардуулгын эсэргүүцлийг хэмжүүлэх

Улсын комисст хүлээн авахад татгалзах зүйлгүй байна.

Д.Бат-Эрдэнэ:

- Цонх чулуун тавцан 2-ын засварт силикон шахаж хийх
- Цахилгаан щитний самбарт таних тэмдэглэгээ сайтар хийж өгөх, ашиглагч байгууллагатай сайн зааварчилгаа өгөх
- Бичиг баримтын бүрдэлийн бүрэн архивт хүлээлгэж өгөх

Байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Э.Болор:

- Гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг хийх
- Гадна фасадны ховхорсон хэсгийг нөхөх
- Узелийн өрөөний тэмдэглэгээ хийх
- Гадна довжооны хагарсан чулуун хавтанг солих

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээн авах саналтай байна.

Э.Чагнаадорж:

Ажлыг фото зургаар баталгаажуулан баримтад хавсаргах. Гишүүдийн өгсөн үүрэг даалгаварын биелэлтээр хүлээж авах саналтай байна.

**Шийдвэрлэсэн нь**: Дундговь аймгийн Сайнцагаан сумын 7 баг " Эрүүл мэндийг дэмжих төв"-ийн барилгыг комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

ГХБХБГазрын мэргэжилтэн Т.Эрдэнэбаяр

Тэмдэглэл хөтөлсөн:

Комиссын нарийн бичгийн дарга Ш.Булганаа